

## БИЕ ХҮНИЙ ТАЛААРХИ ЗАРИМ ФИЛОСОФИ БАРИМТЛАЛУУД

Ц.Пүрэвсүрэн - Ховд ИС, Нийгэм Хүмүүнлэгийн Ухааны Сургуулийн тэнхмийн эрхлэгч

Түлхүүр үг: хувь хүн, бодгаль хүн, бие хүн, бие хүний нийгэмшил, соёл

Эртний грекийн философич Сократ “философи нь ертөнцийг төдийгүй хүнийг танин мэдэх арга хэрэгсэл мөн”, Тейяр де Шарден “Хүн төрөлхтөн үүссэн цагаасаа өөрийгөө хамгийн их судалсан бөгөөд өөрийнхөө талаар хамгийн бага мэдлэг хуримтлуулсан” хэмээснээс үзвэл философийн хүрээнд авч үздэг нэг томоохон асуудал нь хүний асуудал байсан төдийгүй өнөө ч анхаарал татсан хэвээр байгааг илэрхийлж буй хэрэг ажгуу.

XIX зуунаас хойш антропологизм (хүн судлалын үзэл) бол дэлхийн философийн маш чухал нэг хандлага болж ирсэн билээ. “Хүн” гэдэг ойлголтыг философийнхоо суурь категори болгож философитолдынхоо эхлэл ба эцсийн зорилт хэмээн үзэж, ингэхдээ хүний бүхэллэг чанарын аль нэг юм уу зарим хэдэн талыг онцолсон янз бүрийн ойлголтоор түүнээ илэрхийлдэг философи чиглэл дурдан буй үеэс хойш үүсэн, улмаар нөлөө нь өсөх буурах, оршин тогтнол нь хадгалагдах, үгүй болох зэрэг янз бүрийн учрал хувь заяа тэдгээрт үргэлжилсээр байна. Эдүгээ тэр философийг хамтад нь “философийн антропологи” хэмээн нэрлэдэг билээ. Философийн антропологи шүүмжилдэг ба үл зөвшөөрдөг философи сургаалуудын заримынх нь гол үндэслэгээ ёсоор философийн антропологи төлөөлөгчид хүнийг зөвхөн биологи уг чанартайнх нь үүднээс онцлоод хүн бол нийгэм-түүхийн амьтан мөнийг жинхэнэ ёсоор авч үздэггүй аж. Тэд ингэхдээ хүний тухай асуудлыг философи, шинжлэх ухаан зэрэг мэдлэгийн аль ч салбар нэг мөр шийдвэрлэж дийлэхгүй байгаа, хүн бол орчлонгийн нэг өчүүхэн бөгөөд нэн эмзэг хэсэг мөнийг иш үндэс болгодог юм. Гэхдээ орчин үеийн дэлхийн философийн амьдрал дах олон хандлагын нэг болох энэ хэв маягийн философидолт оршин тогтнож, хөгжих оюуны бат хөрстэй юм. Өөрөөр хэлбэл, хүн гэж юу болохыг аль ч философи сургаал зориуд юм уу урсгал байдлаар аяндаа шийдвэрлэж байдаг. Монголд сүүлийн 10 гаруй жилд хүний тухай экзистенциалист, фрейдист, шашны философи г.м. философи чиглэлүүдийн сургаалыг судлан, сурталчлах болжээ. Гэвч өнөөдөр хүний тухай асуудлыг орчин үеийн төвшинд ойлгож авахад “хүний орших модус бол бололцоо мөн” гэдэг нэлээд алдаршсан философи томъёоллын утгыг жинхэнэ ёсоор ойлгох, үүний тулд өрнө, дорнын их сэтгэгчдийн онол, арга зүйн холбогдох үндэслэлүүдийг энэхүү аспектаар дамжуулан судлах шаардлага зүй ёсоор тавигдаж байна. Дээрхи томъёоллын хүрээнд философид хүний (хувь хүн, бодгаль хүн, бие хүн) мөн чанар, оршихуйн асуудлыг авч үзэхдээ түүний биологи гэхээсээ илүү нийгмийн уг чанарт нь гол анхаарлаа хандуулдаг шаардлагатай байдаг.

Оросын философич П.С.Гуревичийн үзсэнээр, индивид (*individum* – латин үг): Хувь хүн гэж хэн бэ? Хувь хүн бол хүмүүсийн нийтлэгийн ба хүн төрөлхтний задаршгүй элемент, эс (ширхэг) болж байдаг агаад хувь хүн нь түүнийг “бусад” олноос ялгадаг. өөрийн өвөрмөц тодорхой шинжтэй байна. Тэр нь хүний хамгийн ерөнхий шинж бөгөөд бүрэн бие даасан бие, байгаль, нийгмийн бодгаль мөн. [3.143.] Судлаач Ц.Балхаажав “Хүн та хэн бэ?” бүтээлдээ “Хүн бол хэмжиж хязгаарлахын аргагүй туйлын их хүч, багтаамж.

дүр төлөв, утга учир агуулсан том ертөнц. Хүний хамгийн гол шинж нь хөгжил гэдэг ойлголтонд багтах бүх өөдлөн дэвшсэн хөдөлгөөний тэргүүн манлай оргил юм” [1.15.] гэжээ. Эндээс харахад хүн бүр өөрийн бие даасан шинжтэй, нэг нь нөгөөтэйгээ бие бялдарын хувьд ч, оюун санааны хувьд ч, сэтгэл зүйн хувьд ч яг ижил биш болохыг илэрхийлж байна. Хувь хүнд нийгмийн харилцаанаас хамааран үүссэн олон чухал шинж байдаг боловч өөрийн давтагдашгүй, онцгой нэгж болж байдаг. Энэ утгаараа хувь хүн бол тал давтагдах онцгой нэгж юм.

Бүтээлч болон практик боломж, чадвар, дадал үр дүн бүхий үйл ажиллагаараа илэрхийлж буй хүнийг бодгаль хүн гэнэ. Өөрөөр хэлбэл, олон янзын авьяас чадвар төдийгүй тэдгээрийн органик нэгдлийг бодгаль чанар гэж үзэж болно. Уран зургийн болон бусад авьяас илрэх нь түгээмэл байсан Италийн сэргэн мандалтын үеэс бодгаль чанарын тухай ойлголт үүсжээ. Бодгаль чанар дахин давтагдашгүй өвөрмөц шинж мөн. Агуулгын хувьд бодгаль чанар нь олон тал шинжтэй. Бодгаль чанар нь төвлөрсөн хэлбэрээрээ бүтээлч үйл явцын дунд ялангуяа урлагт онцгой харагдана. Ямар ба авьяас бүхэн ураачийн гоц шинжийг илэрхийлэхгүй. Леонардо Да Винчи уран зураач гэдгээрээ талхайд алдартай ч тэрээр тал бүрийн авьяастай нэгэн байлаа. А.С.Пушкины зургууд, О.Лермонтовын Кавказын таталбарууд нь өөрийн гэсэн үнэ цэнэтэй бүтээл юм. Орчин үеийн нэрт төгөлдөр хуурч С.Рихтер, Оросын алдарт дуучин агсан Ф.Шалапин, нэрт найруулагч С.Эйзенштейн, С.Параджанова нар гоо сайхан зурдаг байсныг олон хүн мэднэ. Оросын нэрт зохиолч А.Грибейдов, Л.Толстой нар хөгжим зохиодог байжээ. Эдгээр уутнууд тал бүрийн авьяастай байсан ч нэг чадвар нь зонхилж байдаг байжээ.

Философийн түүхэнд тэр дундаа Европын философийн романтик чиглэлийнхэн (В.Гёте, М.Шиллер, Ф.Шлегель) бодгаль чанарын тухай асуудлыг онцгойлон судалж байжээ.

Орчин үеийн судлаачид бодгаль чанар нь хүний өвөрмөц давтагдашгүй олон талт бүхэллэг төрөлхи шинжийг илэрхийлдэг бол бие хүн хэмээх ойлголт нь бодгаль чанар дахь ухамсарт эхлэлд гол анхаарлаа хандуулах ёстой хэмээн үздэг.

Христийн шашин дахь (эцэг-хүү-ариун сүнс) гурвалын тухай асуудал, Эртний Кытадын философич Күнзийн сургааль дахь “эрхэм хүн” хэмээх ойлголт, буддын сургаал дахь “гэгээрсэн хүн” хэмээх ойлголтоос эхлээд Ф.Ницшегийн “супер хүн”, Марксист философи дахь “өв тэгш бие хүн”, Тейярдизм дэх “Омега цэг дэх хүн” гэх зэрэг олон янзын философи ойлголтууд нь бие хүний мөн чанарыг илэрхийлдэг байна.

Бие хүн гэсэн нэр томьёо анх Эртний Грек хэлэнд өнөөгийн утгаараа илэрхийлэгдээгүй юм. Грек хэлний нүүр буюу баг гэсэн үг нь латин хэлний персона, ичино гэсэнтэй утга дүйцнэ. Эртний жүжигчид тоглож буй дүрдээ тохирсон баг өмсөн гүүр хувиргадаг байжээ. Тухайлбал, Римчүүдийн хувьд персона гэдэг нь театрын өдийгүй хувь хүний нийгэмд гүйцэтгэх тодорхой үүргийг илэрхийлсэн ойлголт байлаа. Нийгмийн үүрэг нь тогтмол байдгаараа театрынхаас ялгаатай байжээ. (эцгийн, шүүгчийн, ааны үүрэг г.м.) Өөрөөр хэлбэл, аливаа хүнийг нийгмийн болон оюун ухааны хөгжилтэй үн гэж нэрлэхдээ латины “persona” гэсэн үгийг ашиглаж байв. Энэ үг нь хүний нийгмийн шинж байгалиас дээгүүр байдаг чанарыг илэрхийлдэг.

Христийн шашин нь биет, оюун ухаан, мэдрэмж, хүсэл зоригоор хангагдсан амьд бодгалийн үзлийг илэрхийлдэг. Гэхдээ хүнийг утга учиргүй шүтэн бишрэхийг үгүйсгэдэг байна. Христийн сургаальд ёс суртахууны императивыг гарган ирж, үйл хөдлөлийг нь ийгт хүн төрөлхтний зорилготой харьцуулан үздэг. Өөрөөр хэлбэл, энэ нь И.Кантын “*өөртөө хүсээгүй зүйлийг өрөөл бусдад бүү үйлд*” гэсэн ёс суртахууны императив

зарчимтай төстэй юм. Хүний эрх чөлөө нь ёс суртахууны хуульд үндэслэдэг учраас хүнд сонголтыг тулгадаг байна. Бие хүн тэр бүр дарангуйлагч болохыг тэмүүлээд байдаггүй зэрэгцээ нийгмийн байгууллагуудад өөрийн хувийн атгаг сонирхолоо тулгаад байдаггүй.

Бурхны шашин дахь шарын шашныг үндэслэгч Богд Зонхов Лувсандагва “Их бод мөрийн зэрэг” зохиолдоо хүнийг гурван төрөлхтөн буюу билэгтэн болгон хуваасан байна. Мэдлэг чадвар, сэтгэл бишрэлээр, нимгэн, ерийн ухамсрын хүрээнд ертөнцтэй харьцаа чадвартай хүмүүсийг “өчүүхэн төрөлхтөн” буюу бага билэгтэн хэмээн нэрлээд энэ төрөлхтний оюун ухааны шинж төлөв, түүнийг бодь мөрийн зэрэгт хүргэх аргыг тодорхойлжээ. Ер нь буддизмд хүнийг зовлонгоос ангижруулах арга зам, тухайн хүний оюуны амьдралтай холбоотой хэмээн үзэх учир түүнийг дагаж Зонхов хүнийг оюун чадамжаар нь хуваахдаа бага төрөлхтөн хэмээхийгээ “Аль нэгэн арга аль болгоноор орчлонгийн амгалан төдий ч зөвхөн өөрийн тусад огоорон үйлдэгч тэр нь өчүүхэн төрөлхтөн хэмээн мэдтүгэй” гэсэн буй. Энд ертөнцөд хүмүүс болон төрж хүний аж төрөхийн жам ёсонд татагдан орж, орчлонгийн жаргал зовлонг бие сэтгэлээрээ амсан амьдралын эрэн барааныг өөрийн оюун сэтгэлээр цэгнэн өдөр тутмын амьдралдаа сэтгэл нь ханаж “орчлонгийн амгалан төдийхнийг эрхэмлэгч хүний” хэв маягийг төлөөлөл гаргажээ.

Энэ нь нийгэм дэх бие хүний байдлыг боловсролын байдал оюун санааны чадавхиар баримжаалан тодорхойлж зовлонгоос ангижрах, амгалан сайхныг чин сүжгийг замаар олохыг гол болгосон нь хүнийг сэтгэл зүйн талаас авч үзсэн байна.

Ийм хэв маягийн хүнд нөлөөлж, амьдралын идэвхитэй байр суурьт татан оруулах үндсийг Зонхов сэтгэл зүйн тал хэмээн үзэж шашин шүтэж, чин сүжиг үүсгэх замаар авралын өргөн замд орж, өөрийгөө гэгээрүүлэх замаар хүмүүнлэг ёсыг тогтоох явдал хэмээн үзжээ.

Бага билэгтэн хүний мэдвэл зохих мөрийг энэ ертөнцийн амьдрал мөнх бишийг ухаарах, ирээдүйн амьтны жаргал зовлонг ялгах хийгээд үнэмлэхүй чин сүжгийг төрүүлэх явдал гэж үзжээ.

Тэрээр билигтний хоёр дах хэв маягийг “Дунд төрөлхтөн” хэмээн нэрлээд “сансрын амгаланг араараа зүглээд хилэнцэд үйлээс няцсан өөрийн чанарт аль нэгэн өөрийн амгалан төдийг огоорсон тэр төрөлхтөн дунд хэмээгдэнэ” гэжээ. Дунд төрөлхтөн нь орчлонгийн амьдрал зөвхөн зовлон болохыг ухаарч, түүнийг даван туулах арга замыг эзэмших замаар өөрийгөө аврах мөрийг хүсэгч хүний хэв маяг мөн болно.

Дунд төрөлхтний ухаарах ёстой зүйл бол “Хутагтын дөрвөн үнэн”, найман зовлон (төрөх, өвдөх, өтлөх, үхэх, зохисгүйн, хагацах, үл олохын, цогцын), арван хоёр шүтэв барилдахуйн ёсыг мэдэх явдал болно.

Их төрөлхтөнд тохирох арга бол сэтгэлгээний өргөн асуудлыг хамардгаара мэдлэгийн энгийн хүрээг тэлж өргөтгөхөд хүргэжээ. “Өөрийн сэтгэлд олсон зовлонгоо алимад бусдын хамаг зовлонг үнэхээр барахуйяа бүхнээс таалагч тэр нь их төрөлхтөн мөн болой” хэмээн их төрөлхтний шинжийг илэрхийлжээ. Бурхны сургаалыг ухаарах го зангилаа асуудал буюу амьдралын зовлон, зовлонгийн шалтгаан, зовлонг давах мөрийн танин мэдэх замаар өөрийн дотоод сэтгэлийг ариутган, тэр чанараараа хүнд туслах сэтгэлийн чадвар бүхий хүний хэв маягийг тодорхойлжээ.

Буддизмд хүний мөн чанарыг хэрхэн тайлбарласныг авч үзлээ. Дээрхээс дүгнэвэл хүний ёс суртахууныг үндэслэхийг Будда өөрийн гол зорилго гэж үзсэн байна. Тэд далайн ус ганцхан шорвог амттай байдгийн нэгэн адил миний сургаал ганц авралын амттай байдаг хэмээсэн нь буй. Буддизм нь хүний сүсэг оюунд сэтгэлийн их тайвшрал

дотоод ариуслыг олгож бие, хэл, сэтгэл оюуны хувьд төгөлдөржихийг гол болгодог бөгөөд сэтгэл оюуныг илүү нарийвчлан ангилсан байна. Энэ үүднээс нь буддын философид бие хүний төлөвшилт нь хүний дотоод сэтгэлийн ариусал, ёс суртахууны үнэт зүйлстэй холбон тайлбарласан байна. Дорно дахинд бодгалийг бүхлийн хэсэг буюу бүлэг, хамт олон, нийтлэг, төрийн салшгүй хэсэг хэмээн үздэг уламжлалтай. Тэрээр өөрийн амьдрах орчноо нийгмийн дотор олж, хэт даварсан шаардлагыг тавьдаггүй байна.

Хятадын философич Фэн Ю Лань “Хүний уг чанарын шаштир” зохиолдоо хүний амьдрал, үйл ажиллагааг дөрвөн хүрээнд авч үзжээ. Үүнд, Нэгдүгээрт гэнэн хүрээ бол хүн өөрийн үйлдэл үйл ажиллагааг өөрийн эсвэл нийгмийн заншилд хөдлөгдөн үйлддэг хүрээ. Хоёрдугаарт, хэрэглээний хүрээ бол өөрийгөө ухаарч, өөрийнхөө төлөө бүхнийг хийдэг аминч шинжтэй байдаг. Гуравдугаарт, зан суртахууны хүрээ бол хүн өөрийгөө нийгмийн нэг хэсэг, түүний гишүүн гэдгийгээ ойлгож, нийгмийн сайн сайхны төлөө бусдын сайн сайхны төлөө жинхэнэ шударга зан суртахууны үйл хийдэг хүрээ. Дөрөвдүгээрт, трансцендент хүрээ бол хүн зөвхөн нийгмийн төдийгүй сансрын (Тэнгэрийн иргэн) бөгөөд гэрбээр юу хийлгэж буйгаа ойлгож ухамсарладаг хүний амьдралын дээд хүрээ юм. Түүний үзлээр орчин үеийн философи нь хүнд зан суртахууны болон трансцендент хүрээнд хүрэх арга замыг зааж өгөх үүрэг зорилготой ажээ. Өөрөөр хэлбэл, зан суртахуунт ухаалаг хүнийг төлөвшүүлэхэд философийн (рациональ болон иррациональ зүйлийн) үүрэг ач холбогдол их гэдгийг онцолсон буй.

Английн философич Жон Локк (1632-1702) “Бие хүн бол хуулийн нэгэн ойлголт бөгөөд зөвхөн үхэл зовлон аз жаргалыг мэдэрч чаддаг ухамсарт амьтан буюу хуулийг цагаж мөрддөг хүнд хэрэглэгдэнэ” гэжээ.

Нэрт судлаач Д.Бидней бие хүний талаар судалгаа хийж аливаа бодгальд хоёр төрлийн “эго” (би) байдаг байна. Үүнд, сэтгэл зүйн (байгалиас түүнд заяасан) нийгэм соёлын тодорхой нөлөөллийн үр дүнд бий болсон” эго” байдаг эдгээрийн хоорондын харилцаа ихээхэн зөрчилтэй байдаг. Д.Биднейгийн үзлээр “Бие хүн хэмээх ойлголт нь нүүр царай” (лицо эсвэл персоне) ойлголттой холбоотой юм. Иймд тодорхой соёлтой хувь хүнийг бие хүн гэж ойлгож болно гэж үзжээ. [11.337] Мөн түүний үзлээр “нүүр царай” хэмээх ойлголт нь хүний уг чанар ба соёлын нэгдлийг илэрхийлсэн байдаг. [11.342.] Цааш нь бие хүн бол өөрийн үйл ажиллагаа, оногдсон үүргийг сайтар ухамсарласан байдаг. Энэ шинжээрээ хувь хүнээс ялгаатай гэжээ. Бие хүн бол өөрчлөгдөшгүй зүйл биш. Бие хүний шинжүүд олдмол зүйлс юм. Нэг үгээр хэлбэл, хүн эхлээд хувь болон төрөөд өсөж хөгжин ухамсар суун нийгэмших явцад нийгмийн харилцаанд орж бие хүн болон төлөвшдөг байна. Энд бие хүн төлөвшихөд нийгэм соёлын хүчин зүйлсийн ролийг өндөрт авч үзсэн юм. Өөр нэг дүгнэлт нь хүний нийгмийн мөн чанар нь түүний биологиор нөхцөлдсөн байдаг. Энэ хоёр тал нь харилцан эсрэг тэсрэг боловч мөн нэгдэлтэй байдаг явдал юм. Өөрөөр хэлбэл, энэ талаар биологичлох, нийгэмчлэх өрөөсгөл хандлагууд байж болохгүй гэсэн чухал үндэслэл байгаа юм.

Бие хүний талаар экзистенциализмд онцлог байдлаар авч үзсэн байдаг. “Экзистенциализмын үзлээр хүн эхээс төрсний дараа экзистенцитэй байна (оршино), харин нэлээд хугацаа өнгөрсний дараа ухамсар ба ухамсаргүй оюун санааны нөлөөн дор өссөн (мөн чанараа) олж авдаг” [11.342.] Цаашилбал, хүн өөрийн оршихуйдаа аюул занал учирсан үед өөрийн ахуйн мөн чанар үүрэг хариуцлагаа илүү гүнзгий ухаардаг гэдэгт экзистенциалистууд анхаарлаа хандуулж байв. К.Ясперс, М.Хайдеггер болон бусад философичидын бүтээлд энэ ойлголт тун ховор хэрэглэгддэг. Гагцхүү “хүн”, “бодгаль”, “самость”, “оршихуй (би)” гэх мэт ойлголтууд л илүү хэрэглэгддэг.

К.Ясперс бичихдээ :”Бие хүн хэмээх ойлголт нь хоцрогдсон, инээдэмтэй ойлголт болжээ” [13.71.] гээд бие хүн хэмээх ойлголт нь хүнийг эзэнгүй болгодог гэж шүүмжлээд хүний мөн чанарыг түүний дотор талаас нь (нийгмээс бус) өөрөөс нь гаргаж тайлбарласан байдаг. Энэ талаар манай улсын хүний философийн чиглэлийн судлаач доктор Б.Батчулуун “Философи дахь хүний асуудал” бүтээлдээ “хүний тухай асуудлыг авч үздэг орчин үеийн философийн чиглэлүүдийг харж байхад маш их философидог авч тодорхойлолт өгөх гэж нэг чармайгүй нь анхаарал татдаг. Хүн гэдэг нь геометрийн цэгтэй адил тодорхойлолт өгч болдоггүй нэгэн ажээ” [2.51.] гэж өгүүлсэн байна.

Цаашилбал “бие хүн” гэсэн ойлголтыг Оросын шашны философид олон талаас нь боловсруулсан байдаг. Үүнд В.С.Соловьев нийт хүн төрөлхтний зүйлийн илрэлийн хувьд бие хүн шавхагдашгүйг цохон тэмдэглэж байв. Тэрвээр “хүний бие хүнлэг чанар улмаар нэгж хүн тус бүр хязгаарлашгүй үйл ажиллагааг хэрэгжүүлэх бололцоо төгсгөлгүй асуулгын онцгой хэлбэр мөн” гэж бичсэн байна. Түүний үзлээр бие хүн шавхагдашгүй юм. Тэрбээр үүнд л зан суртахууны философийн аксиом оршино гэж үзэж байв.

Мөн Оросын философич Н.А.Бердяев бодгаль ба бие хүний ойлголтыг дээдараалалтай ялгасан байдаг. Түүний философийн үзлээр бодгаль хүн төрдөг бас үхдэг. Бие хүн төрдөггүй түүнийг бурхан бүтээдэг. Жишээлбэл, бид хоёр бодгаль хүний тухай хэлэлцэе. Ингэхэд тэдгээрийн нэг нь бие хүнлэг чанартай гэж хэлж болно. Энэ бол үнэлэх хандлага юм. Биологийн болон сэтгэл зүйн талаар гойд бодгаль хүн бие хүнлэг чанаргүй байж болно. Н.А.Бердяев бие хүний тухай асуудлыг экзистенциализмийн философийн үндсэн асуудал гэж үзжээ.

XX зууны Германы философич Макс Шеллер бие хүний тухай сонирхолтой сургаал боловсруулж, персоналист ёс зүйг бүтээжээ. Тэрбээр “би” ба “бие хүн”-ийг ялгаж бие хүний үнэт чанар дээр ёс зүйг үндэслэх гэж оролджээ. [6.382.]

Марксист философид бие хүн бол нийгмийн харилцааны субъект, бие хүн бол нийгмийн хөгжлийн бүтээгдэхүүн, хүний нийгмийн шинжийг илэрхийлсэн ойлголт. Бие хүн өөрийн үйл, оногдсон үүргийг сайтар ухамсарласан байдаг. Гагцхүү нийгэмд л бие хүн болж төлөвшдөг хэмээн үздэг. Энэ талаар К.Маркс “Фейербахын тухай сэдвүүд” зохиолдоо “Хүний мөн чанар бол бодгаль тус бүрийн хийсвэр зүйл бус, нийгмийн харилцааны нийлбэр цогц мөн” [5.382.] хэмээжээ. Энэ тодорхойлолтод хүний мөн чанарыг зөвхөн нийгэмтэй холбон тайлбарласан байна. Энэхүү үзэл нь Марксист философид хөдөлмөр нь зөвхөн амьдралын хэрэгсэл төдийгүй бас хүн өөрийгөө бүтээх, оршин байх хэлбэр, үндэс бие хүний нийгэмшилтийн чухал хүчин хэмээн үздэгтэй холбогдоно. Ийнхүү Марксист философийн үзлээр хүн эхлээд бодгаль болон төрж улмаар нийгэмших явцад нийгмийн харилцаанаас олон нийтийн шинжүүдийг (хөдөлмөр, хэл, соёл г.м.) олж авч бие хүн болж төлөвшдөг байна. Бие хүн бол нийгэмшсэн хүн юм.

Ер нь уламжлалт болон уламжлалт бус философийн бүхий л чиглэлд хүний тухай асуудлыг судлах зүйлийнхээ тодорхой бүрэлдэхүүн хэсэг болгон авч үздэг бөгөөд “хүн” бол аливаа философид шууд ба шууд бусаар заавал холбогддог олон философи сургаальд үндсэн категори нь болдог өргөн хүрээтэй ойлголт юм. Тухайлбал, Марксист философид хүн бол нийгмийн бичил зүйл мөнийг онцлон авч үздэг. Байгалийн философид хүний байгалийн амьтан хэмээн үздэг бол шашны философийн зарим төлөөлөгчид хүн бурхан тэнгэрлэг туршлагыг эзэмшиж гэгээрснээрээ бичил бурхан тэнгэр болох чадвартай гэж үздэг байх жишээтэй. Философийн түүхийн өнгөрсөн ба өнөө аль ч үед хүн бол бие сэтгэл, оюун ухаан гурвын нэгдэл мөн гэдэг үндэслэлийг олон философи сургаал хамгаалж иржээ.

Бие хүний психоаналитик онолд (З.Фрейд, К.Г.Юнг, Э.Эриксон, Э.Фромм г.м.) бие хүний ойлголтыг хүний дотоод сэтгэл санааны ертөнцтэй холбон үздэг. Энд хүн биеийн хувьд төдийгүй сэтгэл зүйн хувьд эрийн цээнд хүрэх нь чухам бие хүний төлөвшилт, хүний оршихуйн дотоод хэрэгцээтэй илүү холбон тайлбарладаг.

З.Фрейдийн үзлээр хувь хүн нийгмийн дотор үр ашигтай ажиллах, үйлчлэхийн тулд орчныхоо хүмүүсийн хүлээн зөвшөөрч буй зүйлүүдийг ухаалгаар тусгасан ёс зүйн зохих тогтолцоотой байх ёстой. Энэ бүхнийг хүн нийгэмшлийнхээ явцад буюу психоаналитик загварчлалын хэллэгээр Супер -эго төлөвших явцад олж авдаг байна. Түүний бичсэнээр “Супер эго нь хөгжиж буй бие хүний эцсийн бүрэлдэхүүн хэсэг бөгөөд хэм хэмжээ зан үйлийн дотоод талыг илэрхийлсэн зүйл юм. Хувь хүн Супер эго-той төрдөггүй. Бие хүний ёс зүй, ёс суртахууны хүчин чадлыг илэрхийлж байдгийнхаа хувьд Супер эго нь Эцэг эх, багш болон бусад төлөвшүүлэгч хүмүүсийн нөлөөгөөр хүнд бий болдог” [14.19] гэж үзжээ.

З.Фрейд хүний бүтцийн дээрх гурван давхрагаас гадна хүнд амьдралын инстинкт (Эрос), үхлийн инстинкт (танатос) гэсэн инстинктийн хоёр төрөл байна гэжээ. Энэ хоёр инстинкт нь ухамсаргүй сэтгэцэд багтах бөгөөд бие хүний сэтгэц дэх мөргөлдөөний уг сурвалж болдог төдийгүй хүний авир үйлдлийн явцад энэ хоёрын үйлдэл ямагт хамт оршин мөнхөд зөрчилдөж байдаг гэж үзсэн байдаг. Тэрээр “Хүн төрөлхтний амьдралд гэмүүлэх хүсэл эрмэлзлэл, бүтээлч сэтгэлгээ, хайр дурлал, сексийн мэдрэмж Эрос дээр үндэслэдэг. Харин харгис хагуу түрэмгий үйл, амиа хорлох болон аллага хядлагын үндэс Танатос болж байдаг” [15.99] гэж үзсэн нь хүнийг уг чанраараа хоёрдмол шинжтэй гэсэн үзэл санааг нь бас илэрхийлдэг.

Философийн антропологийн нэгэн томоохон төлөөлөгч болох ХХ зууны нэрт гүн ухаантан Э.Фроммын үзлээр орчин үеийн нийгэмд зонхилж байгаа бие хүний 5 хэв шинж байна. [8.246.] Эдгээр хэв шинж нь цэврээр оршдоггүй хувь хүнд ийм хэв шинжүүдийн аль нь давамгайлж байгаагаас хувь хүний сэтгэцийн эрүүл мэнд үүрэг хариуцлага ихээхэн шалтгаалдаг ажээ. Э.Фромм бие хүний шинжийг:

**1. Бэлэнчлэх хэв шинж:** Амьдралын аливаа сайн сайхны эх сурвалж нь тэднээс өөрсдөөс нь ангид оршино гэж үздэг. Тэд илэрхий хамаарамтгай идэвхигүй хүмүүс бөгөөд бусдын туслалцаагүй юу ч хийх чадваргүй хүнийг хайрласанд орвол хайрлагдаж байх нь амьдралын гол зорилго гэж үздэг.

**2. Дарангуйлах хэв шинж:** Өөрийн хүсэж мөрөөдөж буй болон өөрт хэрэгтэй байгаа бүхнээ орчноосоо хүчээр авагчид. Эд ч мөн бүтээлч байх чадваргүй хүмүүс бөгөөд хайр энэрэл, үзэл санаа, сэтгэл хөдлөл зэргийг бүгдийг нь бусдаас зээлж авдаг.

**3, Хуримтлуулах хэв шинж:** Материаллаг зүйлс, эрх мэдэл, хайр энэрэлийг аль болохоор их хэмжээгээр хуримтлуулахыг хүсэгчид өөрсдийн хуримтлалд халдах аливаа сандлагаас зайлсхийгч хүмүүс.

**4, Зах зээлийн хэв шинж:** Хүнийг худалдаж ашиг олж болох эсвэл сольж болох эд бараа мэт үзнэ. Иймд хүмүүс гадаад төрх байдлаа аятайхан байлгаж ашигтай хүмүүстэй харьцаа тогтоох өөрт нь ашигтай бол өөрийгөө сурталчлах аливаа боломжийг алддаггүй байна.

**5, Заг төлөвийн үр бүтээлт шинж:** Энэ нь бие хүний хөгжлийн эцсийн зорилго юм. Ийм хэв шинжийн хүмүүс нь биеэ даасан шударга, тайван, бусдыг хайрладаг бүтээлч, нийгэмд ашигтай үйлдэл хийх чадвартай. Бүтээлч сэтгэлгээнийхээ ачаар хүмүүс “би” гэж эн бэ? гэдгийг мэддэг учраас өөрийн төөрөгдлөөс чөлөөлөгддөг. Үүнийг хайр халамж, хариуцлага, хүндэтгэл, мэдлэг зэрэг үзүүлэлтийн тусламжтайгаар Э.Фромм тодорхойлжээ.

Үнэн хэрэгтээ бол Э.Фроммын хүмүүнлэгийн онол дахь зан төлөвийн үр бүтээлт хэв шинж нь хүний хөгжлийн туйлын байдлыг илэрхийлж байгаа юм. [9.]

Доктор Р.Дарьхүү бичихдээ: “хүний талаархи философийн судалгаанд “хүн”, “бие хүн”, “бодгаль” гэсэн нэр томъёонуудыг хэрхэн ойлгохоос эхлээд бэрхшээл үүсдэг. Хүн бие хүн, бодгаль ойлголтууд нь нэгэн төрлийн боловч яг адилхан биш ээ. Эдгээр ойлголтуудын ялгаа нь тэдгээрийг туйлын эсрэг тэсрэг байдалд аваачих ёсгүй” [4.] хэмээн үзсэн буй. Ийнхүү философийн антропологийн судлах зүйлийн бүтцэд өнөө үед бие хүний үүрэг хариуцлагын асуудал чухал байр эзэлсээр байгаа болно.

Сүүлийн үед бие хүн хэмээх ойлголтыг өөр шинэ агуулгаар баяжуулан авч үзэх болжээ. Доктор Н.Сарантуяа хэлэхдээ “өөрийн амвдралын утга учир буюу өөрийн мөчлөх чанарыг хэрэгжүүлэх тодорхой хөтөлбөртэй, өөрийн ухаан, ухамсар, интуици буюу дээд ухамсараа удирдах чадвартай, өөрийн мэдээлэл – эрчим хүчний орон зайд амьдрах түүнийг удирдан залах чадвартай хүмүүнийг бие хүн гэнэ. Энэ хүмүүнд дан ганц нийгмийн хөтөлбөрийн хүрээнд амьдрах нь хангалтгүй. Бусдын буруу үзлийн вирус нийгмийн эмгэг бүтцүүдийн үл зөвшөөрөх идэвхитэй байр суурьтай, мэдээлэл, эрчим хүчний давуу хөгжилтэй хүмүүн өөрийгөө болон нийгмийг эрүүл байлгах чадамжтай байна” [7.11-12.] хэмээн чухал санааг дэвшүүлжээ.

XIX зууны сүүлийн хагасаас хойш бий болсон сонгодог бус философийн ололч чиглэлд хүн судлалын чиг баримжаа давамгайлдаг болсон нь хүний оршихуй хямрал шинжтэйг ухамсарлаж хүн онтологи, “орон гэргүй”-г ба байр суурь нь бэхжээгүй илрүүлж бас гарцаагүй хязгаарлагдмалыг нь болон санаархлынхан эвдэгч шинжийг хүлээ зөвшөөрсөн зэрэгтэй холбоотой ажээ. Хүнийг ийнхүү ухаарч түүний тухай философ тайлбар хийх байдал нь натуралист, экзистенциалист, нийгэмд захируулах үндсэн гурвал өөр хандлагаар илэрдэг байна.

Гэвч эдгээр хандлага хүний тухай асуудлын зөвхөн тодорхой хэсгийг авч үзэх шийдвэрлэх зорилго тавьж ирсэн байна. Иймээс хүний тухай бүх л цогц сургаалий философи, шинжлэх ухааны ололтуудыг нэгтгэн ашиглах замаар бүтээх оролдлого гарч үүний үндсэн дээр “философийн антропологи” гэдэг салбар XX зууны 80-аад онд бий болсон [10.247.] хэмээн доктор Ц.Гомбосүрэн тэмдэглэжээ.

Өмнө өгүүлсэн үзэл баримтлалуудаас нэгтгэн авч үзвэл, бие хүн бол дан ганц нийгмийн үзэгдэл бус, учир нь хүн уг чанараараа байгалийн ч, нийгмийн ч хоёрдмо шинжтэй байдаг. Өөрөөр хэлбэл, хүн байгаль ба нийгэмд аль алинд харьяалагддаг билээ. Хүн нэг талаар байгалийн амьтан учир байгалийн хуулинд захирагддаг, нөгөө талаар нийгмийн амьтан учир бас нийгэмтэй дасан зохицож, түүнийгээ өөрчлөн хувиргах хэрэгтэй болдог. Энэ үйл явц нь бие хүний нийгэмшилтээр нөхцөлдөн бий болдог болохыг философийн аль ч баримтлалын хувьд хүлээн зөвшөөрч иржээ. Иймээс бие хүний нийгэмшилт гарцаагүй чухал юм.

Энэ утгаараа бие хүн гэдэг нь нийгмийн орчин нөхцөлтэй дасан зохицож, өөрчлөн хувиргаж, үүрэг хариуцлагаа ухамсарласны үндсэн дээр эрхээ ухамсарлан амьдарч оршиж буй бодгаль болно. Бие хүн гэдэг нь өөрчлөгдөн солигдож байдаг нийгмийн төрх буюу үүрэг биш харин зан төлөвийн хэм хэмжээг чөлөөтэй сонгосноороо өөрийн ёс суртахуунаа тогтоож байдаг нийгмийн идэвхитэй бодгаль юм. Бие хүн хүчтэй ба сул, эерэг ба сөрөг зөрчилтэй шинжийг хадгалж байдаг. Бие хүн нь үйлдлийн буюу бодит үйл хэргийн эзэн бөгөөд түүнд үйлдэгдэх зориг эрмэлзлийн эхлэл заавал байдаг. Энэхүү зориг эрмэлзлийн эхлэл дотоод болон гадаад гэсэн хоёр чиглэлтэй.

Бие хүн сэтгэлийн зориг тэнхээгээрээ өөрийгөө өөрчлөхөд чиглэсэн тийм зан төлөвийн эерэг буюу сөрөг чанарыг шинээр эзэмшихэд чиглэсэн боломжуудыг дотоод зориг эрмэлзлэл гэнэ. Гадаад ертөнцөө өөрчлөхөд чиглэсэн чармайлтыг гадаад зориг эрмэлзлэл гэнэ. Заримдаа аливаа нийгмийн үзэл санааг хэрэгжүүлэхийн тулд бусдын хүсэл зоригд захирагдах хэрэгтэй болдог тал бий. Нийгмийн зорилго нь мөн чанараараа дэвшилттэй ба ухралттай, хүмүүнлэг ба хүмүүнлэг бус г.м. олон янз байдаг. Түүхэн годорхой нөхцөлд тодорсон бие хүн олон түмнийг араасаа дагуулан нийгмийн дэвшилд хүрэх эсхүл сүйрэл авч ирэх нь ч бий.

Хэрэгцээ сонирхол, түүнийгээ илэрхийлэх хэлбэр зэргийг агуулсан нийгмийн гүвэгтэй бүтцийг бие хүн илэрхийлж байдгийг бид мартаж болохгүй. Ялангуяа зорилго нин эрмэлзэл буюу нийгэм соёлын үнэт зүйл үүнд ихээхэн үүрэгтэй. Хүн төрөлхтний нийтлэг үнэт зүйлийн цогц болох соёлтой бие хүний соёлын хэмжүүр ч салшгүй холбоотой. Соёлын хөгжлийн түвшин нь амьдралын хүмүүнлэг хэв маягийг бий болгох урьдчилсан нөхцөл болж өгдөг. Нийгмийн бүх гишүүдэд шударга хууль үйлчилж байна гэдгийг ухамсарласан иргэн нь хүмүүнлэг нийгэмд шилжих үндсэн нөхцөл мөн. Хүн төрөлхтний нийтлэг шалгуурт тохирсон үндсэн хуулийн зарчим үйлчилж буй үед нийгэм оюун санааны зохих төвшинд байдаг. Соёлын өндөр төвшинд ард түмэн ажиллаж амьдрах нь нийгмийн дархлалын систем эрүүл байх нөхцөлийг бүрдүүлдэг. Нийгмийн институт дахь ардчиллын түвшин нь нийгмийн эрүүл байдлаас шууд хамааралтай. Нийгмийн соёл өндөр байх тусам түүний институт ардчилсан шинжийг хадгалж нийгмийн ардчилсан байдал соёл өндөр байх нь зүйн хэрэг юм. Эдгээрийн хоорондын уялдаа холбоо хүн бүхэнд ил байх нь хүний тодорхой шинж төлөв мөн.

Тэгэхлээр бие хүн бол нийгмийн хуулийг даган зохирогч идэвхигүй субъект бус, харин ч өөрийгөө болон нийгмийг сайтар таньж ухаарсан, тэр үндсэн дээр өөрийгөө ч нийгмийг ч шинэчлэн боловсронгуй болгох арга ухаан, чадвартай хүн хэмээн үзэж байна.

Эцэст нь дүгнэж үзвэл бие хүн бол нийгмийн нэг үндсэн элемент эс ширхэг юм. Бие хүн нь хүний хамгийн ерөнхий шинжүүдийн зэрэгцээ өөрийн давтагдашгүй онцгой шинжүүдийг агуулсан бие даасан байгаль нийгмийн амьтан мөн. Бие хүн нь биологийн төдийгүй нийгмийн олон талын хэрэгцээ шаардлагаар нөхцөлдөн амьдардаг. Бие хүний амьдрал, үйл ажиллагаа, ололт, дутагдал нь түүний үүрэг хариуцлагаа хэрхэн ойлгож хэрэгжүүлж байгаагаас нэлээд их хамаарна. Энэ утгаар нь бие хүний нийгэмшилт гэдгийг хүмүүс өөрийн нийгэмд хүлээсэн зохих дүр үүрэгтэйгээ уялдуулан тогтсон хандлага, ухаан суух үйл явц гэж үзэж болно.

### Резюме

В философии главное внимание обращается на сущность и существование личности (индивид), на связь и отношения личности к обществу. А также необходимо рассматривать в философии особенности рациональности и иррациональности человека как умаственного субъекта.

### Ишлэл авсан бүтээлүүд

1. Ц.Балхаажав Хүн та хэн бэ? УБ.,2001.
2. Б.Батчулуун. Философи дахь хүний асуудал.УБ.,2001.
3. П.С.Гуревич "Индивид-человек" М.,2000.
4. Р.Дарьхүү. Хүний талаархи философийн судалгааны арга зүйн зарим асуудал. МУИС-ийн эрдэм шинжилгээний бичиг. УБ.,1996,№2.



5. К.Маркс. Ф.Энгельс Түүвэр зохиол I боть УБ.,1978. тал.2.
6. Человек “Философско-энциклопедический словарь” М.,2000.
7. Н.Сарантуяа. Бие хүний хөгжлийн зарим асуудал ба харилцааны соёл - Өнөөгийн залуусын харилцааны соёлд хийсэн шинжилгээ УБ.,2004.
8. Л.Хьем Д.Зиглер Теорий личность. СПб.,1997.
9. Э.Фромм. Имеет или быть. М.,1989.
10. Философи (Сурах бичиг) УБ.,2002.
11. D.Bidney. Thoretical. Antropology. New – York – London. 1964.
12. L.Miller. Questions Thad matter. 1987.
13. K.Jaspers. Philosophie and Welf. Munchen.1958.
14. З.Фрейд. Бие хүний онол дахь психодинамик чиг хандлага УБ., 2007.  
/Орч., О Мягмар/
15. З. Фрейд. Я и Оно СПб., Алейя 1999